



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.08.18 № 31

Төсвийн тухай хуулийн хэрэгжилт
болон Улсын Их Хурлын гишүүдээс
тойргийн хөрөнгө оруулалтад
санал авсан талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1.2000-2004 онд 10 сая төгрөгөөр эхэлсэн нэг гишүүний тойргийн мөнгө 2026 оны байдлаар 5 тэрбумд хүрч 500 дахин нэмэгдэж, нийт гишүүдийн 2025 оны тойргийн хөрөнгө оруулалтыг тооцоолбол 510 тэрбум төгрөг хүрэхээр байна. Үүнийг төсвийн үргүй зардлыг нэмэгдүүлж, төсвийн нэгдсэн бодлогыг алдагдуулан, төсөвт тавих Улсын Их Хурлын хяналтыг сулруулсан шийдвэр гэж үзэж байна.

Нийт гишүүдэд хуваарилж буй мөнгөн дүнгийн Улсын төсөвт эзлэх хувь нь 2004 онд 0.1 хувь, 2012 онд 3.79 хувь, харин тухайн жилийн төсвийн тэнцэлд (алдагдалтай) эзлэх хувь нь 2004 онд 1.93 хувь, 2022 онд 29.4 хувь болсон бол 2026 онд 37.36 хувь болж өсөхөөр байна.

Иймд өнгөрсөн онуудад нэгдсэн төсвөөс тойргийн мөнгө нэрээр Улсын Их Хурлын гишүүдэд мөнгө хуваарилсан үндэслэл, нийгэм, эдийн засагт гарсан үр дүн, Сангийн яамнаас явуулсан санал, холбогдох баримт болон Засгийн газраас цаашид баримталж буй бодлого, байр суурийн талаар;

2.Улсын Их Хурал болон Засгийн газар хоорондын эрх мэдлийн тэнцвэрийг хадгалж, парламентын хяналтыг үр дүнтэй байлгах нь ардчилсан тогтолцоо, парламентын засаглалыг төлөвшүүлэх үндэс юм. Таны эхлүүлсэн “Үндсэн хуулийн реформ”-ын нэг зорилго нь хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагуудын бүтэц, эрх мэдэл, чиг үүргийг тодорхой болгож, зааг ялгааг тодруулахад чиглэсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2/-т зааснаар “Улсын нэгдсэн төсөв”-ийг боловсруулах нь Засгийн газрын, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7/-т зааснаар улсын төсвийг хэлэлцэх, батлах, төсөвт хяналт тавих нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаардаг. Иймд төсвийн төсөл боловсруулах явцад Улсын Их Хурлын гишүүдээс санал авч байгаа нь энэ удаагийн Улсын Их Хурал төсөв батлах эрхээ бие даан, хараат бусаар хэрэгжүүлэхэд нөлөөлж, улмаар засаглал хуваарилах, төрийн эрх мэдлүүд тэнцвэртэй, харилцан хяналттай байх, ашиг сонирхлоос ангид байх, хууль дээдлэх зэрэг зарчимтай зөрчилдөж буй эсэх талаар;

2025000055

3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2007 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн их суудлын хуралдаанаараа “Улсын Их Хурлын гишүүдэд тойргийн мөнгө хуваарилсан нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн” тухай 02 тоот тогтоолоор хянан шийдвэрлэснийг цаашид жишиг болгон баримтлах эсэх талаар;

4.Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо хөрөнгө оруулалт хуваарилуулж, байгаа нь гишүүний үүрэгт хамааралгүй төдийгүй иргэдийн саналыг худалдан авахад чиглэсэн, сонгуулийн үндсэн зарчмуудыг зөрчсөн, улс төрийн соёлыг гажуудуулсан үйл ажиллагаа мөн эсэх талаар;

5.Улсын Их Хурлын гишүүдээс тойргийн хөрөнгө оруулалтад санал авч төсөвт тусгаж байгаа нь “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Улсын төсвийн нэгдсэн бодлогод тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхтэй уялдаж байгаа эсэх болон ямар нөлөөлөл үзүүлж байгаа талаар;

6.Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 33 их наяд 479.5 тэрбум, зарлагын дээд хэмжээг 33 их наяд 479.5 тэрбум байхаар тооцсон буюу алдагдалгүй төсөв батлахаар байна. Төсвийн зарлагыг орлогын хэмжээгээр төлөвлөсөн нь хэрэгжиж буй томоохон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт болон төрийн албан хаагчдын үндсэн цалин, цалингийн нэмэгдэл зэрэг зайлшгүй шаардлагатай зардлуудыг нэмэгдүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж буй эсэх талаар;

7.2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд Засгийн газрын өрийн нийт хэмжээ нь Дотоодын нийт бүтээгдэхүүний 50 хувь байхаар төлөвлөсөн. Өрийн зарцуулалт нь “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн зарим хэсгийг хойшлуулах тухай бодлоготой уялдаж байгаа эсэх, зарим мега төслийг хойшлуулж буй тохиолдолд өрийн хэмжээг бууруулах боломжтой эсэх талаар;

8.2025 оны төсвийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэхэд Улсын Их Хурлын гишүүдийн тойрогтоо хийх хөрөнгө оруулалтын талаар ирсэн саналуудыг ирүүлэх, цаашид төсөвт иргэдээс санал авах асуулгад энэ талаар асуулт оруулах эсэх талаарх зэрэг болно.

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ч.ЛОДОЙСАМБУУ

2025000055